# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
# ТОГТООЛ

2019 оны 6 дугаар сарын 19-ний өдөр | Дугаар 248 | Улаанбаатар хот

Усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн төлбөрийн жишиг батлах тухай

Усан замын тээврийн тухай хуулийн 5.1.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн төлбөрийн жишиг"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Усан замын тээврийн шинэ хэрэгслийг эхний 2 жилд техникийн хяналтын үзлэгт оруулахгүйгээр зөвхөн тооллогод хамруулж байхаар тогтсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд У.ХҮРЭЛСҮХ

Зам, тээврийн хөгжлийн сайд Б.ЭНХ-АМГАЛАН

УХ 40064

Засгийн газрын 2019 оны 248 дугаар
тогтоолын хавсралт

## УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГИЙН ТӨЛБӨРИЙН ЖИШИГ

| Тээврийн хэрэгслийн ангилал | Тээврийн хэрэгслийн их биеийн урт (метр), суудлын тоо | Нэг удаагийн төлбөрийн жишиг (төгрөгөөр) |
|---|---|---|
| Усны мотоцикл | 3 м хүртэл урттай, 2-оос ихгүй хүний суудалтай | 20000 |
| Жижиг | 5 м хүртэл урттай, 4-өөс ихгүй хүний суудалтай | 25000 |
| Бага | 5-20 м урттай, 12-оос ихгүй хүний суудалтай | 50000 |
| Дунд | 20-50 м хүртэл урттай, 60-аас ихгүй хүний суудалтай | 100000 |
| Том | 50 м болон түүнээс илүү урттай, 60-аас дээш хүний суудалтай | 150000 |

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН
ХӨГЖЛИЙН ЯАМ
УХА0382
Бүртгэсэн № 6105
Огноо 2019-07-08
цаг минутанд
шилжүүлэв